Вопросы систематизации и классификации лексики, ее семантического развития и происхождения имеют большое значение для реконструкции языковой картины мира того или иного народа или этноса. Фундаментальность заявленной проблематики и научной задачи, на решение которой направлено исследование, обеспечивается постановкой проблемы в типологическом ракурсе. Изучение лексики материальной и духовной культуры, выявление ее этимологии и семантических характеристик – давняя традиция мировой монголистики и алтаистики. Сегодня требуются комплексный подход к анализируемому материалу, создание лексической базы данных, применение современных информационных технологий. Доклад опирается на данные лексикографических источников, старописьменных памятников, фольклорных и художественных текстов, а также архивных и полевых материалов. Предметом пристального внимания авторов явятся те лексические элементы, которые несут определенную культурно-историческую информацию. Исследования такого рода будут способствовать развитию современного калмыцкого языка, постижению глубины традиционных знаний, менталитета и мировоззрения монголоязычных народов, помогут восполнить имеющиеся пробелы и обобщить накопленные к настоящему времени данные, а в дальнейшем – в полной мере развернуть широкие сравнительно-исторические исследования в данной области.

### “Монголын нууц товчоон” дахь нэрийн болон үйлийн орхилт

Г.Баттогтох

*МУИС-ийн Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим*

М.А.К.Халлидэй (M.A.K.Halliday), Рукайяа Хасан (Ruqaiya Hasan) нар эхийн холбоосжилт (cohesion) -ын тогтолцоог судалж, “Англи хэлний холбоосжилт” (Cohesion in English) хэмээх номыг бичиж хэвлүүлсэн бөгөөд уг бүтээлдээ төлөөлүүлэл (reference), орлуулал (substitution), орхилт (ellipsis), холбоос (conjunction), үгийн сангийн холбомж (Lexical cohesion) зэрэг ойлголтухагдахууныг тодорхойлсон байна (1976). Хэл шинжлэлч нар Үүргийн тогтолцоот хэл зүй (Systemic Functional Grammar-SFG) онолын хүрээнд боловсруулсан,

дурдсан тогтолцооны дагуу аливаа хэлний холбоосжилтыг судалж буй жишгээр монгол хэлний холбоосжилтоос “Монголын нууц товчоон” дахь нэрийн болон үйлийн орхилтын жишээг сонгон авч, зүй тогтлыг нь тайлбарлахыг зорив. Монголын нууц товчоонд буй үйлийн орхилтын зарим жишээнээс ажиглавал, эцэст өгүүлсэн санаанд буй үйл үгийг орхиж, эхний хэсэгт тэг хэлбэрээр илрүүлэн өгүүлдэг байна.

## **Способы передачи и перевода безэквивалентной лексики (на примере монгольских текстов)**

Васильева Дугвэма Натар-Доржиевна

*Кафедра восточных языков переводческого факультета МГЛУ*

Доклад посвящен проблеме передачи безэквивалентной лексики в различных видах текстов на монгольской письменности, опубликованных и написанных в XX веке на территории России, раскрывает виды данной лексики на примере иноязычных слов и терминов. Цель исследования - анализ способов передачи безэквивалентной лексики в оригинальном текстовом пространстве с монгольского языка на русский.

Мы рассмотрим понятия «термин», «лакуна» и «реалия», изучим их реализацию на уровне исследуемых текстов, подробно остановимся на наиболее интересных способах передачи лексических единиц при помощи транскрипционных знаков «галик» (галиг үсэг) и основных способах перевода анализируемой лексики. В процессе перевода исследуемых текстов (несколько видов очерка, архивные документы, дидактическое сочинение, жизнеописание) мы применили следующие способы передачи безэквивалентной лексики, как беспереводное заимствование, калькирование, транслитерация, описательный перевод и др.

## **A comparative study of Mongolian Verbal nominal suffixes “-mar/-mer” and “-m\_a/-m\_e”**

Bao Gegen

*Major in Multicultural Studies Graduate School of  
Modern Society and Culture, Niigata University*

This paper aims to explore the grammatical features and usage of the verbal nominal suffixes «-mar/-mer» and «-m\_a/-m\_e» in Mongolian. By analyzing the morphological changes, syntactic functions and semantic expressions of these two suffixes in detail, this paper will illustrate their different applications and grammatical rules in



Mongolian. The grammatical contrast and differences between these two suffixes are also discussed, as well as their role in syntactic structure and semantic expressions. Through a comprehensive study of these suffixes, this paper aims to provide learners and researchers of Mongolian with a deeper grammatical understanding and an accurate guide to their application.

## Монгол хэлний нийлмэл эгшгийн бүтэц, үүрэг

Д.Уртнасан

*ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн*

In the Mongolian language, monophthongs, diphthongs, and long vowels differ in the meaning of words and exist at the phonemic level, while the compound vowels *ua*, *uo*, and *uy* function independently from phonemes. This paper will focus on the structure and function of those compound vowels in terms of acoustic phonetics, articulatory phonetics, and morphophonemics.

In traditional phonetics, compound vowels *ua*, *uo*, and *uy* are considered differently as diphthongs, long vowels, and etc. According to the results of the present study, those vowels do not show phonetic value of diphthong, but they show phonetic value of long vowels and they are pronounced shorter than simple long vowels in Mongolian language.

The derivation is related to front vowel and the post-consonant (naturally, final *u* vowel) soft sign that marks front vowels. The condition to form compound vowels is created by adding suffixes *-aa*, *-oo*, *-yy*, and noun formation suffixes starting with *-aa*, *-oo*, *-yy*. For example, *захь+aa=захиа*, *дохь+oo=дохио*, *дахь+уул=дахуул* etc.

Compound vowels are always long vowels, and one of the two combined vowels is usually longer than the other. Mongolian compound vowels together with front vowels /æ/, /œ/, /ɣ/ function to form syllables in words with more than two syllables.

## К вопросу о фразеологической вариантности в монгольских языках

Бадмацыренова Надежда Бадмажаповна  
*Бурятский государственный университет*

Фразеологизму, как и слову, присуще явление вариантности. Под вариантностью понимаются лексико-грамматические изменения компонентов, не приводящие к нарушению их семантического тождества. Непременным условием тождества фразеологических единиц является наличие в их вариантах одного общего

компонента и сущность их лексического значения. Вариантность формы фразеологических единиц связана: 1) с разграничением уровней варьирования – фонетическая, словообразовательная, морфологическая, синтаксическая и лексическая варианты; 2) с усечением компонентного состава фразеологических единиц – количественная вариантность; 3) с количеством варьируемых компонентов – двучленная, многочленная варианты. Замена компонента фразеологической единицы меняет характер ее образного представления, ее оценочную, стилистическую окраску и ведет к образованию синонимов. Лексические варианты фразеологизма находятся в пределах одной и той же синтаксической конструкции» и не вносят каких-либо смысловых оттенков в содержание фразеологизма. В монгольских языках выделяются следующие типы структурных вариантов: 1) лексические – ФЕ, в которых один или несколько компонентов подвергаются изменению; 2) грамматические – ФЕ, в которых один из компонентов изменяет грамматическую структуру; 3) квантитативные – ФЕ, в которых варианты отличаются числом компонентов.

### Миньхэ монгор хэлний үг бүтээх зарим дагаврын уламжлал, шинэчлэл

Шиотани Шигэки  
Осака Их Сургууль

Монгол төрөл хэлнүүдийн нэг болох Миньхэ монгор хэлний үг бүтээх зарим дагаврыг тусгайлан авч монгол бичгийн хэл, дундад үеийн монгол хэл, орчин цагийн монгол хэлтэй харьцуулан үзсэний дүнд тус хэлний дагаврыг 1. “Эртний монгол хэлнээс уламжлагдаж ирсэн дагавар”, 2. “Миньхэ монгор хэлэнд шинэчлэгдсэн дагавар”, 3. “Миньхэ монгор хэлний өвөрмөц дагавар” хэмээн гурав хувааж болохыг тодруулсан болно.

Энэхүү өгүүлэлд дурдсан Миньхэ монгор хэлний нэрээс нэр бүтээх дагавар нь 1. **-buri [-buri], -ker [-k□], 2. -ge [-□□]/-ku [-ku], -ghulu [-□ulu], -si [-s□], -tang [-t□η], 3. -her [-x□]** болно.

### Code-copying in Uyghur Uriankhay (Tuhan)

Ragagnin, Elisabetta  
Università Ca' Foscari Venezia

Tuhan - one of the most intriguing and enigmatic Siberian Turkic varieties – is presently spoken by a handful of speakers in the village of Tsagaan Üür to the East of Khövsgöl lake. The language is severely endangered. The intergenerational transmission is

interrupted and children do not learn the language anymore.

With regard to classification, Tuhan belongs to the Steppe Sayan Turkic group together with Standard Tuvan and its dialects, and Altay-Sayan varieties spoken in China and western Mongolia.

Tuhan holds a special position within Sayan Turkic. Besides displaying those features that characterize Sayan Turkic as a whole, it shares some specific isoglosses with Tofan. Based on such linguistic evidence, in Ragagnin (2009) I had defined Tuhan a “low-land Tofan variety” as opposed to high-land or taiga- Tofan” represented by the variety described by Rassadin (a.o. 2006) in several publications. At the same time, Tuhan displays unique lexical and grammatical features that distinguish it from the rest of Sayan Turkic; see Ragagnin (2009, 2013, 2018 and 2018a).

Finally, Tuhan holds a special position within Sayan Turkic also regarding Mongolic elements. In my paper I will discuss Tuhan lexical, morphological and syntactic features resulting from contact with diverse Mongolic varieties, adopting the Johansonian code-copying framework.

## **Монгол хэлний харьяалахын тийн ялгалын айн хэв шинж**

О.Самбуудорж

*ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн*

Монгол хэлний жинхэнэ нэр нь байгаль, нийгмийн юмс, үзэгдлийг нэрлэж тоо, тийн ялгал, хамаатуулахын айгаар хувилдаг, өгүүлбэрт гол төлөв үйлийн эзэн, тусагдахуун болон туслах үйл үгтэй хавсран өгүүлэхүүний үүрэг гүйцэтгэдэг, хамгийн их судлагдсан үгийн аймгийн нэг юм. Гэвч бид энэ илтгэлд орчин цагийн монгол хэлний харьяалахын тийн ялгалын айн үндсэн хэв шинжийг тодруулан өгүүлэх болно. *Тухайлбал*, монгол хэлний жинхэнэ нэрийн харьяалахын тийн ялгал нь хэлний хөгжлийн явцад бий болсон хэлбэр буюу дуудлагын үндсэн 3 хэв шинжтэй байдаг бол, бичлэг буюу зөв бичих дүрмийн *-ийн* (*-ын*), *-(г)ийн*, *-ий* (*-ы*), *-н* 6 хувилбар бичлэг буюу хэв шинж, түүнчлэн юмсын харьцааг тэмдэглэж санааг илэрхийлэх гэсэн бидний ойлголтоос шалтгаалсан харьцаа буюу үүрэг, хэрэглээ буюу утгын олон хувилбар хэв шинжтэй байдаг байна.

Монгол хэлний тийн ялгалын айн өөр нэг өвөрмөц онцлог бол тодорхой ойлголтыг давтан хэлэхгүй гэсэн бидний ойлголт, хэлний хэмнэлттэй холбоотой хүн тухайн үгийг нь хураан хэлэвч, хэл зүйн хэлбэрийг нь харьцаа заах шаардлагын улмаас үл хураан хэлэх учир өөр тийн ялгалын айн хэл зүйн хэлбэр харьяалахын тийн ялгалын нөхцөлийн араас давхарлан орох тохиолдол монгол хэлэнд арвин бий болсон байдаг байна. Иймд илтгэгч энэ илтгэлд монгол хэлний харьяалахын тийн ялгалын айн хэв шинжийг хэлбэр буюу дуудлага, бичлэг буюу зөв бичих дүрэм, харьцаа буюу үүрэг, хэрэглээ буюу утга, үндэс буюу хэлний хэмнэлтийн хэв

шинжтэй хэмээн үзэж байгаа болно.

## **Монгол хэлний үнэлэмж илэрхийлэх тэмдэг нэрээр үйл үгийг тодотгох тухай**

Ямада Ёхэй

*Токиогийн Гадаад Судлалын Их Сургууль*

Монгол хэлний хэлзүйн бүтээлүүд дээр “тэмдэг нэр нь нэр үгийг тодотгохоос гадна үйл үгийг ч гэсэн тодотгож болдог” хэмээн тэмдэглэгдсэн байдаг. Хэдий тийм боловч ихэнх бүтээлүүдэд нэг хоёр жишээ л дурдсан байдаг бөгөөд чухам ямар тэмдэг нэрээр ямар үгийг тодотгож болох тухай өгүүлээгүй байна. Тиймээс энэ илтгэлд хөмрөгт суурилан, “сайн, муу” гэх утгатай үнэлэмж илэрхийлэх зарим тэмдэг нэрийг судална. Мөн тухайн тэмдэг нэр тус бүр нь хэдий хэмжээний үйл үгийг тодотгож болох эсэхийг тодруулна. Жишээлбэл их хэрэглэгдэх “сайн” гэдэг үг орсон 50 жишээг шалгаж үзэхэд, үүний ихэнх хувь буюу 40хувь “сайн мэднэ” гэх мэт үйл үгийг тодотгосон байна. Мөн нэр үгийг тодотгосон нь 26хувь, өгүүлэхүүний үүргээр орсон нь 12хувь байна. Үүнд тогтсон хэллэг, мөн ямар үүргээр хэрэглэгдэж буйг ангилахад хэцүү жишээ ч бий. Мөн “сайн” гэдэг үгээр тэмдэг нэрийг тодотгосон жишээ ажиглагдаагүй. Үүнээс үзвэл тухайн тэмдэг нэр тус бүр нь өөр өөр харьцаагаар бусад үгтэй холбогдож болно гэдгийг таамаглаж байна.

## **Орчин цагийн монгол хэлэн дэх гадаад үгийн хэрэглээний асуудалд (Нийгмийн сүлжээний жишээгээр)**

Э.Мөнх-Учрал

*МУИС-ийн Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим*

Орчин цагийн монгол хэлэнд гадаад үгийн хэрэглээ ихсэж байгаа талаар нэлээд шүүмжлэнгүй ханддаг. Ингэхдээ зарим нэг нийтлэг жишээ дурдах замаар авч үзсэн нь түгээмэл боловч бодит хэрэглээнд тулгуурласан судалгаа хараахан үгүй байна. Тиймээс, энэхүү илтгэлд мэдээний сайтууд, Жиргээ, Нүүр номыг багтаасан нийгмийн сүлжээний хүрээнд медиа мониторингийн систем ашиглан монгол хэлээрх 12 сая орчим нэгж бүхий боловсруулаагүй өгөгдлийг бодит хугацаанд (real time) цуглуулан бичил хөмрөг бүрдүүлж, тус хөмрөгөөс гадаад үгсийг ялган авч үгийн сан, зөв бичих зүйн үүднээс судлах зорилт дэвшүүлсэн болно. Тус судалгааны дүнд, гадаад үгийн хэрэглээ монгол хэлний толь бичгүүдэд орсноос

4-5 дахин их байгаа төдийгүй тэдгээрийг зөв бичих зарчмыг хэрэглэгчдэд тодорхой болгож, гадаад үгийн толь бичгийг шинэчлэх шаардлагатай байгааг харуулах болно.

### **Монгол хэлний “Insubordination” нь үйлийн нөхцөлдүүлэн холбох нөхцөл болон үйлт нэрийн нөхцөлөөр илрэх нь**

Н.Лхагважав

*Токиогийн Гадаад Судлалын Их сургууль*

Монгол хэлний “Insubordination”-ы талаарх судалгаа хараахан өргөн дэлгэр бус байгаа бөгөөд одоогоор монгол хэл судлаач Ямакошигийн 2016 онд гаргасан судалгаа бий. Тэрээр уг судалгаандаа Монгол, Буриад, Минхэ монгуор, Кангжа, Баоань, Дунсян, Шар уйгар, Хуцзу-Монгуор хэлнүүдэд энэхүү үзэгдэл бий хэмээн үзсэн бөгөөд монгол хэлний хувьд болзох сул үг ‘бол’-оор илрэх “insubordination”-ы талаар өгүүлсэн байдаг. “Insubordination” гэдэг нь нийлмэл өгүүлбэрийн гишүүн өгүүлбэр (subordinated clause)-ээр л нэг бүтэн өгүүлбэр (sentence)-ийг байгуулах ёс мөн” хэмээн Ямакоши тодорхойлсон. Харин энэхүү судалгааны ажилаар бид монгол хэлний үйлийн нөхцөлдүүлэн холбох нөхцөлөөр болон үйлт нэрийн нөхцөлөөр илрэх “insubordination”-ны тухай өгүүлэх болно. Монгол хэлэнд болзох сул үг “бол”-оос гадна “insubordination”-ийг илэрхийлэх арга бий гэдгийг энэхүү судалгаандаа өгүүлэх болно.

### **Каузативные эмотивные конструкции в бурятском языке**

Skribnik, Elena

*Ludwig-Maximilian-Universität München*

Даржаева Надежда Баировна

*Институт монголоведения, буддологии и тибетологии СО РАН*

В докладе рассматриваются комбинаторные характеристики самых частотных глаголов каузации эмоций в бурятском языке. Базовыми актантами при таких глаголах считаются Стимул эмоции (обычно в роли подлежащего) и Экспериенцер (обычно в роли прямого дополнения), а также Каузатор, Инструмент и Приём. На базе Корпуса бурятского языка исследована сочетаемость этих глаголов с именами различной семантики и возможные синтаксические конструкции с их участием. Анализ выявил, во-первых, что обнаруженные конструкции представляют собой систему, позволяющую говорящему поставить в фокус внимания разные компоненты Стимула. Информационно наиболее значимый компонент оформляется как подлежащее; это может быть событие-Стимул в

целом (представленное придаточным или именем действия) либо его главное действующее лицо (Каузатор); при Каузаторе в конструкции может быть дополнительно выражен центральный предметный участник как Инструмент либо само действие как Приём. Во-вторых, эти конструкции существенно различаются в зависимости от типа Стимула (непосредственно события или информация о них), причём Стимулы информационного характера гораздо частотнее Стимулов-событий, что показывает значимость коммуникативного фактора в языковом сообществе.

## **Дундад үеийн монгол хэлний үгийн сангийн бүрэлдэхүүний үндсэн шинж**

Б.Энхсүвд

*МУИС-ийн Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим*

Энэхүү өгүүллээр өдгөө бидэнд уламжлагдан ирсэн монгол хэл, бичгийн хамгийн анхны дурсгалаас эхлээд дундад үеийн монгол хэлэнд хамаарах монгол, дөрвөлжин, хятад болон араб үсэг бичгээр буй 270 гаруй сурвалжид тулгуурлан бичиг тус бүрээрх дурсгалын үгийн сан гаргахаас гадна нийт үгийн санг бүртгэн гаргав. Ингэснээр нийт үгийн сангийн бүрэлдэхүүнийг уугуул болон харь үгээр ялгаж, тэдгээрийг үгийн аймгийн хүрээнд авч үзэхээс гадна орчин цагийн монгол хэлний үгийн сангай харьцуулан идэвхтэй ба идэвхгүй үгийн санг тодруулахыг зорьсон билээ. Үүний дүнд судалгааны санд буй ерийн үгийн хүрээнд нэр үг голлох бөгөөд бүрэлдэхүүний хувьд 90 гаруй хувь нь уугуул үг, хэрэглээний хувьд 90 орчим хувь нь орчин цагийн монгол хэлнээ уламжлагдан ирснийг тооцоолон гаргав. Түүнчлэн зарим үгийн утга нарийссан, өөрчлөгдсөн хийгээд салаа утга нь мартагдсан зэрэг үйл явц тодорхой хэмжээнд гарчээ. Харин идэвхгүй үгийн санд орсон үгийн ихэнх нь харь гаралтай үг, үйл үг, албан тушаал болон зэрэг дэвийн нэр байх ажээ.

## **О китайских заимствованиях в старописьменном монгольском языке: лексикографический аспект**

Сьжэньдаолима

Харанутова Дарима Шагдууровна

*Бурятский государственный университет*

В нашем докладе речь пойдет о китайских заимствованиях в языке шэнэхэнских бурят, проанализированных с точки зрения их семантической адаптации. Китайские заимствования, выбранные из лексикографических источников на старописьменном монгольском языке, свидетельствует об их освоении языком

шэнэхэнских бурят. Выявленные заимствования разделены на условные четыре группы: с сохранением значения, с сужением значения, с расширением значения и с переосмыслением значения.

### **Уникальные ли монгольские причастия или похожи на урало-алтайские (в том числе на венгерские)?**

Tóth Zsolt  
*Institute for Hungarian Studies*

Санжеев характеризует монгольские причастия следующим образом: «...в своём непредикативном использовании могут окказионально обозначать не только действие, но и исполнителя, объект или результат действия...». Хотя в грамматиках урало-алтайских языках обычно не встретимся подобной оценкой, это не обозначает, что урало-алтайские причастия не обладают – минимум диахронно – с этими же чертами, свойственными монгольским причастиям. По-моему, это является следствием того – игнорируемого в лингвистических описаниях – факта, что урало-алтайские причастия – особенно перфективные – могут выполнять роль имени действия (*nomen actionis*). Кроме того, из этого факта вытекает: 1) морфологическая особенность причастий, что могут склоняться по падежам и управляться послелогом, и в некоторых случаях принимать и суффикс множественного числа или лично-притяжательный суффикс; 2) синтаксическая особенность, что могут выступать в качестве и таких членов предложения как дополнение и обстоятельство. Хотя венгерский является одним из урало-алтайских языков в котором характер причастий резко изменился, даже ныне явно видно, что венгерские причастия исконно имеют высокую степень типологического сходства с монгольскими и другими урало-алтайскими.

### **Агглютинативность и проблемы фонеморфологических корреляционных модификаций в монгольских языках**

Биткеев Петр Цеденович  
*Калмыцкий государственный университет*

Решения актуальных проблем современной монголистики нередко требуют учета характера и тенденции развития разных уровней системы исторического прошлого языка.

**“Уурын тэрэг, чийчаан, машин, жийп”: автомашины холбоотой нэршил, үг хэллэгийг харилцаа хэлшинжлэлийн үүднээс шинжлэх нь**

Вероника Капишовска  
Карлын Их Сургууль

Одоогоос зуу гаруй жилийн өмнө тухайн үеийн техник, технологийн цоо шинэ дэвшилтэт унаа болох автомашин Монгол оронд анх орж ирснээс хойш хот хөдөөг хамарсан бүхэл бүтэн шинэ соёл үүсч бий болжээ. Үүнийгээ дагаад шинэ цагийн унаа тэрэгтэй холбоотой автомашин гэх мэт үг хэллэг монгол хэлэнд нэвтрэн орж монгол хэлний үгийн сан баяжиж байгаа нь зүй ёсны хэрэг юм. Монгол жолооч нар эхэн үедээ Хятад, дараа нь ихэнхдээ Орос буюу ЗХУ-аас орж ирсэн автомашин жолоодох, засах ур чадварыг хятад, орос, буриад жолооч, засварчдаас сурсны нөлөөгөөр машин унаатай холбоотой үг хэллэг, нэршил монгол хэлэнд нэгэнт тогтжээ. Сүүлийн хорь гаран жил бусад газраас оруулж байгаа автомашиныг дагалдан тоног төхөөрөмж, тоноглолын шинэлэг англи нэршил ч нэмэгдсээр байна. Ийм болохоор хотын болон хөдөөгийн монгол хэлэнд шингэсэн, эхнээсээ өнөөдрийг хүртэл ээлжлэн монгол хэлтэй харьцаанд орсон гурван өөр хэлнээс гаралтай автомашинтай холбоотой үг хэллэг нь монгол хэлэнд идээшсэн харь гаралтай үгийн байдлыг харуулсан нэг ёсны бичил орчин болж байгаа гэж үзэх үндэслэлтэй юм. Иймд, илтгэлдээ Naugen (1953)-ы санаачилж, Winford (2003)-ын ерөнхийлөн дэлгэрүүлсэн “үгийн сангийн түвшинд харь хэлний харьцааны нөлөөнд үүссэн бүрэлдэхүүний ангилал”-д тулгуурлан автомашины нэршлийн дотроос харь үг болон түүний үүсмэл үг (1-3), хуулан орчуулсан үг (4-5), уугал монгол үгийн семантикийн өргөтгөл (6) зэргийг хувилбаруудын (3) нь хамт шинжилж хэлэлцүүлнэ.

(1)

*багааж* < ор. *багажник*

(2)

*хааз* < ор. *газ*

*хааз-ла-* < *хааз* < ор. *газ*

(3)

а) *тоормсог* < ор. *тормоз*

б) (*тоормос-ло-*) < *тоормос* < ор. *тормоз*

(4)

*салхины шил* < ор. *ветровое стекло* (cf. англ. *windshield / windscreen*)

(5)

*шил арчигч* < ор. *стеклоочиститель*



(6)

*жолоо* (маш.) < *жолоо* (хоёр үзүүрийг хазаарын зуузайд уясан, морь, малыг залах битүү оосор)

## **О названии люльки-качалки в монгольских языках**

Бальжинимаева Баярма Дашидондоковна  
*Бурятский государственный университет*

В статье рассматриваются обычаи и обряды, связанные с рождением ребенка, названия люльки-качалки и ее частей в монгольских языках.

Детская колыбель является центром обычаев, обрядов, которые связаны с народными представлениями о сохранении жизни ребенка, о его благополучии в будущем.

По сведениям информантов, заблаговременное изготовление колыбели может пророчить какое-нибудь несчастье: неудачные роды, болезнь или преждевременную смерть ребенка. Колыбель изготавливали лишь только после рождения ребенка, либо занимали ее у родственников, иногда у односельчан, у которых вырастал здоровый ребенок.

## **Plural pronoun constructions in two varieties of Mongolian: Description and typological considerations**

Lim, Jun Jie  
*University of California*

Plural pronoun constructions (PPCs) refer to coordinated noun phrases wherein a plural pronoun may receive an inclusive singular interpretation. In this paper, I show that PPCs can be found in Khalkha Mongolian (1) and Kalmyk Oirat (2).

- (1) Chi bid hoyor tsuivan id-sen.  
2SG 1PL two tsuivan eat-PST  
'You and I ate tsuivan.'  
Not: 'You and us ate tsuivan.'
- (2) Badma ma xojər mandʒ-igə tʃok-u-vidŋ  
B.NOM 1PL two M.-ACC hit-PST-1PL  
'Badma and I hit Manj.'  
Not: 'Badma and us hit Manj.'

Both Khalkha and Kalmyk PPCs obligatorily require i) a plural pronoun and ii) a numeral, iii) can only have an inclusive reading. Additionally, iv) the plural pronoun must follow the other coordinate noun phrase. Interestingly, Khalkha PPCs are restricted to 1PL and 2PL pronouns, while Kalmyk PPCs seem to be restricted to only 1PL pronouns. I also discuss differences between Mongolian PPCs and PPCs in other languages.

## **Буриад хэлний тайлбар толь бичиг зохиох асуудлууд**

Сундуева Екатерина Владимировна

*Институт монголоведения, буддологии и тибетологии СО РАН*

Дөрвөн ботит «Буриад хэлний тайлбар толь»-ийн гол зорилго нь буриад ард түмний хэлний сайхан, баялагийг харуулах, хадгалах, түгээн дэлгэрүүлэх болно. Үүнийг эмхэтгэх ажил 60 орчим жилийн хугацаанд явагдаж байна. 2022 онд А–Д үсгүүдээр эхэлсэн 8 мянга гаруй үгийн тайлбарыг агуулсан толийн нэгдүгээр боть Улаанбаатарт хэвлэгдэн гарсан. Одоо Е-Р үсгүүдээр эхэлсэн үгсийн тайлбарыг багтаасан хоёрдугаар ботийн ажил дуусч байна. Энэхүү толь бичиг буриад ард түмний хэдэн зууны турш зохиож байсан үгсийн сан, хэлц үг хэллэгийн баялагийн төвлөрсөн хэлбэрийг тусгасан болно. Үгийн утга, хэрэглээний онцлогийг уран зохиол, шинжлэх ухаан, нийгэм, улс төрийн уран зохиол, хэвлэл мэдээллийн хэрэгслээс жишээ болгон харуулав. Үгсийн дүрмийн тайлбарыг өгч, найруулгын тэмдгийг өгсөн болно. Толь бичгийг эмхэтгэж дуусаад толь бичгийн цахим хуудас гаргахаар төлөвлөж байна. Буриад ард түмний мэргэн ухааны шимт чанарыг агуулсан энэхүү толь бичиг буриад хэлийг хадгалах, хөгжүүлэх, тэр дундаа улам бүр хүчээ авч буй дижитал технологийн ачаар бүрэн үйлчлэх болно гэж зохиогч-эмхэтгэгчид найдаж байна.

## **On the transitivity of Modern Mongolian: Through a comparison of Mongolian dialects**

Kurebito Tokusu

*Tokyo University of Foreign Studies*

Үйл үгийн үйлт чанар бол өгүүлбэр зүй болон үгийн утга зүйн нэгэн онцлог шинж гэж хэлж болно. Norper&Thompson (1980) хоёр эрдэмтэн үйл үгийн үйлт чанарын чанга сулын зэргийг хэмждэг утга зүйн болон хэлзүйн талаар 10 зүйлийн шалгуур гаргасан байдаг. Тэдний энэ 10 шалгуураар монгол хэлний үйл үгийн үйлт чанарын чанга сулыг шалган үзэх нь нэг сонирхолтой асуудал болж байна. Үйл үгийг тосох ба эс тосох гэж хоёр төрөлд ангилдаг. Харин орчин цагийн

Монгол хэлний аялгуунд зарим үйл үгийн тосох ба эс тосох чанар нь хоорондоо ялгаатай байна. үгсийг шилжилт, шилжилт бус үйл үг гэж хуваадаг

Энэхүү илтгэлдээ би Монгол хэл аялгуунуудын бодит жишээг харьцуулан, үйл үгийн үйлт чарар ба тосох үйл үгийн утга чанар, үйл үгийн үйлдэгдэх хэв ба үйлдүүлэх хэвийн хэвийн хоорондын харьцааг тодруулахаар зорьж байна.

## **Монгол хэлний хотогойд аман аялгуу**

С.Мөнхсайхан

*ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн*

Монгол улсын баруун хойд хязгаарын Тэс, Дэлгэрмөрөний сав газар буюу Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Төмөрбулаг, Бүрэнтогтох, Цагаан-Уул, Арбулаг сум, Завхан аймгийн Баянтэс, Баянхайрхан, Тэс, Асгат, Нөмрөг, Тэлмэн сумдад хотогойд хэмээх өвөрмөц нутгийн аялгуу, ёс заншил бүхий цөөн тоот угсаатны бүлэг амьдран суух бөгөөд тэд олон зууны ээдрээ нугачаат түүхэн үйл явдлыг туулан өнгөрүүлсэн монгол угсаатны салшгүй нэгэн хэсэг юм.

Хотогойдуудын тухай “Монголын нууц товчоо”, “Судрын чуулган” зэрэг сурвалжуудад дурдсан байдаг нь тэднийг эртний гарал угсаатай хүмүүс болохыг илтгэн харуулдаг. Эрдэмтдийн судалгаа болон түүхийн баримтаас үзвэл Хотогойд нь Ойрадын Хойд аймгаас салж халхчуудын дунд суусан бөгөөд ингэхдээ бас зах хаяа нийлэн амьдарч байсан Тува Енисейн хиргис, тэлэнгэд зэрэг овог аймгуудаас олзлон авчирсан хүмүүстэй холилдон нэгэн угсаатны бүрэлдэхүүн болж Халхын Засагт хан аймгийн баруун болон баруун хойд хэсэг буюу зүүн талд Сэлэнгэ, Тамир голын эхнээс баруун тийш Хархираа, Түргэний уулс, хойд зүгт Тагна уул хүрсэн өргөн уудам газар нутагт харьцангуй бие даасан байдалтай амьдарч байжээ. Иймээс эдгээр хүмүүс нь хэл аялгууны хувьд өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой боловч нэлээн халхжсан байдаг. Нутгийн аялгууны хуваарилалтын хувьд хотогойд аман аялгууг анхандаа ойрад аялгууны салбар аман аялгуунд оруулдаг байсан бол сүүлийн үед халхын салбар аман аялгуунд оруулах болсон байна. Хотогойд аялгууны талаар тусгайлсан дорвитой судалгаа хийгдээгүй бөгөөд Орос, Зөвлөлтийн эрдэмтдийн бүтээл, Хэл зохиолын хүрээлэнгээс зохион байгуулж байсан хээрийн шинжилгээний ангийн /Ж.Цолоо, М.Шинэхүү нарын цуглуулсан/ зарим материал зэрэг цөөн тооны судалгаа байдаг. Гэхдээ эдүгээ халх аялгууны нөлөөнд нэлээн автсан хотогойд аялгууны хувьд эдгээр материалууд нь уг хэл аялгууг судлах үнэтэй эх хэрэглэгдэхүүн хэвээр байна.

Энэхүү илтгэлээр хотогойд аман аялгууг судалсан өмнөх судалгааны тойм болон Хөвсгөл аймгийн Төмөрбулаг, Цэцэрлэг, Цагаан-Уул, Бүрэнтогтох сумаар хотогойд аман аялгууны байцаалт хийсэн хээрийн шинжилгээний судалгааг танилцуулахын хамт хотогойд аялгууны одоогийн байдлыг ерөнхийлөн дүгнэх болно.

## **Аман сурвалжийн үгийн сангаас хорчин нутгийн аялгууны үгийг тодлох нь**

М.Жавхлан

*МУИС-ийн Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим*

Хорчин аман аялгууны нэгэн сурвалж 1984 онд 62 цагаар хуурдан хэлсэн бэнсний үлгэр болох “Гурван улсын үлгэр”-г үгийн сангийн талаас нь судлах явцдаа хэрхэн аман бичгийн сурвалж болж монгол хэлний нутгийн аялгууны ховор чухал баримт болсныг бататгаж, 1984 оны хорчин аман аялгууг төлөөх сурвалж хэмээн үзэв.

Бичгийн хэлэнд “ном бичгийн хэл”, “аман бичгийн хэл” гэдэг хоёр зүйл хуваан үзэж болох бөгөөд тус сурвалжийг аман бичгийн хэлэнд хамруулна үзсэн юм. Харин тухайн үлгэрийн үгийн сангаас илэрч буй нутгийн аялгууны аман ярианы хэлэн дэх нутгийн аман аялгуу дотор багтаан үзлээ.

Энэ нь нутгийн аялгууны судлалд бэнсний үлгэрийг хараахан хамруулдаггүй байсныг илрүүлсэн юм.

Мөн бусад орчуулгуудтай үгийн санг харьцуулан үлгэр дэх хорчин аман аялгууны 14 эртний үг, авианы хувьсал бүхий 18 үг, бусад аялгуунаас үгийн бүтцээр ялгаатай 9 үг, бусад аялгуутай адил боловч найруулга хэрэглээний ялгаатай 22 үг, тухайн аялгууны өвөрмөц 18 үгсийг ангилан тайлбарлав.

## **Монгол хэлний нутгийн аялгуу судлалд Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтдийн оруулсан хувь нэмэр**

С.Энхжаргал

*ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн*

Энэхүү илтгэлд Хэл зохиолын хүрээлэнгийн нутгийн аялгуу судлаач эрдэмтдийн хээрийн шинжилгээний ангиар явсан тайлан, албан томилолтын үр дүн, судалгааны ололт амжилтын тухай болон эрдэмтдийн анхаарлын төвд ямагт байдаг монгол хэлний нутгийн аялгуунуудын ангиллын талаар Хэл зохиолын хүрээлэнгийн Эх хэл бичгийн сан хөмрөг болон Архивын газарт хадгалагдаж буй хээрийн шинжилгээний ангийн тайлан, баримт хэрэглэгдэхүүнээс тодруулан үзэх болно.

Өнөөдөр монгол хэлний нутгийн аялгууны судалгаанд 1950, 1960-аад оноос эрчимтэй эхэлсэн ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын

сурвалжилсан хээрийн шинжилгээний ангийн тайлан бүтээлийг нэгтгэн дүгнэх ажил чухал шаардлагатай болж байна. Одоогоор бид монгол хэлний нутгийн аялгууны тухай хүрэлцээтэй ганц сэдэвт зохиол, олон зуун эрдэм шинжилгээний өгүүлэл, баялаг эх хэрэглэгдэхүүн хэвлэсэн нь гадаадад төдийгүй Монгол Улс дахь монгол хэл шинжлэлийн нутгийн аялгуу судлалын нэг гол амжилт мөн. Гэвч монгол хэлний нутгийн аялгууны салбарт шинэлэг уур амьсгалыг оруулах цаг нэгэнтээ ирсэн байна.

Нутаг нутгийн өвөрмөц аялгуу нь нийгэм цаг үеэ даган хувьсан өөрчлөгддөг жам ёсны үзэгдэл тул өнөө цагт өнгөрсөнтэй нь харгуулан зэрэгцүүлж, дахин авч үзвэл нэн сонирхолтой юм.

### **Language contact among closely-related languages: intentional borrowings and purist discourses in Kalmyk and Buryat**

Baranova Vlada  
*Das Nordost-Institut /IKGN e. V.*

The paper aims to discuss the recent contact-induced language changes in Kalmyk and partly in Buryat. During the Soviet time, Buryat and Kalmyk were separated from other Mongolian varieties. After 1990, there are contacts with other Mongolic languages, most important with other Oirat varieties for Kalmyk/Oirat and with standard Khalkha for Buryat. Many language planners at the time spoke of the need to cleanse Kalmyk and Buryat of Russian borrowings and replace them with Mongolian ones. New dictionaries were being published. The report examines the community's attitudes towards these forms and provides examples of such language contact.

### **Монголын нууц товчоо хийгээд орчин цагийн монгол хэлний зарим нутгийн аялгууны үгсийн тухай**

Боржигин Оюун  
*Өвөр Монголын Багшийн Их Сургууль*

“Монголын Нууц Товчоон” бол монгол үндэстний хамгийн анхны бичгийн зохиол, монголын эртний түүхийн гурван их тулгар бичгийн нэг нь мөн бөгөөд өнөр баялаг хэл хэллэгтэй болохоор эртний монгол хэл, монгол хэлний улирал хөгжил тэрчлэн орчин цагийн монгол хэл, аялгууны судалгаанд чухал материал болж байдаг.

“Монголын Нууц Товчоон”-д илэрсэн аль олон үгс дотроос нэг хэсэг үгс нь орчин цагийн монгол хэл аялгуунд адил бус хэмжээгээр уламжлагдан хадгалагдсаар иржээ.

Тус өгүүлэлд орчин цагийн монгол хэлний өвөр монгол аялгууны хорчин, ар хорчин, урад зэрэг аман аялгуу хийгээд ойрад, барга, буриад аялгуунд уламжлагдан хэрэглэгдэж байгаа “Монголын нууц товчоон” дахь үгсээр жишээлэн, нарийн бодитой тодорхойлон задлаад, монгол хэл аялгууны судлалд “Монголын нууц товчоон”-ыг ашиглахын чухал чанарыг дурджээ.

## ХАНЫН ИЛТГЭЛ (Poster presentations)

### Монгол хэлний ялгах ёс заах төлөөний үгээр илрэх тухай асуудалд

Б.Пүрэвсүрэн

*МУИС-ийн Европ судлалын тэнхим*

Орчин цагийн монгол хэлний заах төлөөний үг төлөөлөх, заах үүргээс гадна онцлон ялгах, тухайлан ялгах үүрэгтэй болохыг тодруулсан судалгааны үр дүнг танилцуулна. Заах төлөөний үг нэрийн зүйлийг онцлон ялгах үүрэг монгол хэлэнд бодитой илрэх, зүй тогтолт үзэгдэл болохыг академич Ш. Лувсанвандан судлан тогтоож, 1953 онд хэвлүүлсэн “Монгол хэлэн дэх ялгах ба үл ялгахын ёсон” өгүүлэлдээ тайлбарласан. Заах төлөөний үгийн тухайлах, ялгах үүргийг Академич Д. Төмөртоогоо (Д.Төмөртоогоо, 2008) түүхэн хэл зүйн судалгаагаар нотолж, мөн профессор Ц. Шагдарсүрэн (Ц.Шагдарсүрэн, 2010) монгол хэлний заах төлөөний үг европ зүгийн хэлний “...ялгацын үүргийг давхар гүйцэтгэдэг” тухай өгүүлсэн. Бид заах төлөөний үгийн ялгах ёсонд хамаарах онцлон ялгах утгаас гадна тухайлан ялгах утгыг тусгайлан ангилж, өдөр тутмын сонины бичвэр болон ярианы сан гэсэн хоёр санд хийсэн тооцоонд үндэслэн, хэрэглээний үүргийг тодруулан үзсэн болно. Эмпирик судалгааны зэрэгцээ үүсгүүр өгүүлбэр зүйн онол, арга зүйд үндэслэн заах төлөөний үгийн хэрэглээний байрыг шинжилж, нэр үгийн референтийг тухайлан заах утга илэрхийлэх нэгжийн үүргээр орохдоо тодотгогч бүрдүүлбэрийн байранд байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. Монгол хэлний заах төлөөний үг тухайлах, ялгах утга илэрхийлэх үүргийн хувьд энэтхэг-европ бүлгийн хэлний ялгацын үүргийг гүйцэтгэдэг онцлогтой бөгөөд онцлон ялгах, тухайлан ялгах хэрэглээний утга нь хэл ярианы үүдэл, логик зүй тогтлоос хамааралтай, олон хэлэнд түгээмэл үзэгдэл гэдгийг өгүүлсэн судлаачдын үзэл баримтлал мөн монгол хэлний баримтаас үзэхэд илэрхий байна.

### **A quantitative study on the semantic role distribution characteristics of modern Mongolian adjectives**

Бао Инхуа

Давхарбаяр

*Өвөр Монголын Их Сургууль*

Semantic role study falls under the scope of shallow semantic analysis, which is the only way to realize deep semantic analysis. This paper conducted a quantitative investigation of the semantic role of adjectives in modern Mongolian using a multi-level tagged corpus. According to statistical analysis, there are 881 adjectives in the multi-level

tagged corpus that have played 18 semantic roles. There are 1202 occurrences of these adjectives in the frequency range of 1-692, with the majority occurring in the range of 1-50. The distribution of semantic roles is fairly uneven, with status (cin) being the most prevalent one. Based on these findings, the paper performed a probability distribution fitting analysis on the distribution characteristics of the semantic roles of modern Mongolian adjectives. The fitting results show that the distribution of semantic roles in modern Mongolian adjectives is regular and follows the Right truncated modified Zipf Alekseev distribution model, different style corpus have a certain impact on the distribution characteristics of the semantic roles of modern Mongolian adjectives.

## **Идиомы как фактор самоидентификации в бурятском фольклоре**

Дампилова Людмила Санжибоевна

*Институт монголоведения, буддологии и тибетологии СО РАН*

Говоря о национально-культурной идентичности, фольклорный текст является одним из основных маркеров отличительных особенностей этноса. В кратких образных выражениях монгольских народов зачастую требуется расшифровка этнически закодированного слова. Выявляя идиомы на уровне формульных сочетаний и отдельных лексем в корпусе текста, определены тематические разделы по их основным коммуникативным и образно-выразительным функциям. Идиомы в тексте формируются по их формальным, структурным и содержательным признакам. Повтор идиом как этнически обозначенных константных единиц занимает основную позицию в устном творчестве. Выявлены устойчивость и вариативность идиом как доминантных единиц, которые представляют собой стержневой элемент повествования.

## **Юанийн дуурилгад тохиолдох монгол үгийн авиа зүйн онцлог**

Бай Тингин

*Монгол Улсын Их Сургууль*

Юанийн дуурилга (元曲) бол Юань улсын үед цэцэглэн хөгжсөн утга зохиолын хэлбэр бөгөөд тухайн үед зарим хүн үүнийг “домог(传奇)” хэмээн нэрлэдэг байжээ. Тан улсын үед үүссэн “дуурилга” хэмээх бүх төрлийн урлагийн ерөнхий ойлголт мөн Сүн, Алтан улсын дуурилгын онцлогоос ялгахын тулд “Юанийн дуурилга(元曲)”, “Юанийн зажюй/(元杂剧)”, Хөгжмийн найруулгын хувьд Юанийн дуурилга нь хойд зүгийн хөгжимд тулгуурлан зохиогдсон учир “Хойд зажюй (北杂剧)” хэмээн нэрлэжээ. Юань улын уран зохиолын төлөөлөл бүтээл болох Юанийн дуурилга нь өмнөх үеийн дуурийн урлагийн суурин дээр тулгуурлан хөгжиж



тухайн үед хөгжлийн оргилын үед хүрч, тайзан дээр жүжиглэн тоглох хэлбэр нь Хятад үндэстний дуурилгын тоглолтын түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Юаний дуурилгын зохиолд тохиолдох монгол үг, хятад хэлэнд орж хэрэглэгдэхдээ ямархүү бичилтийн онцлогоор тэмдэглэгдэж байсныг мэдэхийн тулд XIII зууны үед хамаарагдах монгол, хятад хэлний авианы тогтолцоог онолын талаас гардан танилцаж, үүний сууран дээр туайн үед бичигдсэн монгол авиаг хятадаар тэмдэглэсэн түүхэн дурсгал болох “Монголын нууц товчоон”, “Хуа-й й-юү хятад-монгол толь бичиг”, ойрх үеийн хятад хэлний авиаг тэмдэглэсэн “Хятад хэлний түүхэн ноорог” зэрэг бүтээлүүдийг ашиглан, дуурилгын зохиолд монгол үг орж хэрэглэгдэх ярианы хэлний авианы онцлогийг гардан танилцуулна.

### **Монгол хэлний орших орны утга илтгэх дагавар -на<sup>4</sup>/ -(н)аа<sup>4</sup> -ийн хэрэглээ болон онцлог**

Б.Мөнхдарам

*Токиогийн Гадаад судлалын Их сургууль*

Орчин цагийн монгол хэлэнд орших утга илтгэх дагавар -на<sup>4</sup> хэрэглэгддэг нь тодорхой боловч гадна, дотно, наана, цаана гэх орны харьцааны үгсийг язгуур дагавраар нь задлан салгаж үзэх нь ховор мэт ажиглагдаж байна. Бас нэг зүйлийг дурдвал асуух төлөөний үг хаа, хаана хоёр нь ижил утга, үүрэгтэй гэж зарим судлаач үзэж байна. Тухайлбал асуух төлөөний үг хаа нь хар ярианы хэлэнд хэрэглэгддэг ба хаана -тай ижил утгатай гэж үзсэн бол хаана нь үгийн бүтцээр задрах боломжгүй гэж тайлбарласан бүтээл ч байна. Иймээс орших утга илгэж буй -на<sup>4</sup> дагаврын онцлог, үг зүйн бүтэц, хэрэглээг дахин нарийвчлан судлах шаардлагатай байна. Мөн -на<sup>4</sup> дагавартай ижил утгаар хэрэглэгдэж буй -(н)аа<sup>4</sup> дагаврын талаар ч мөн судалж чухам тус тус ямар утга, үүргээр хэрэглэгдэж буйг хөмрөгт тулгуурлан судална. Мөн өгөх оршихын -д/-т нөхцөлийн хэрэглээтэй уялдуулж ялгаатай талыг тайлбарлана.

### **Монгол хэлний тайлбар толиудад толгой үгийг тогтоож ирсэн уламжлал, арга зүйн асуудалд**

Ж.Хишигжаргал

*Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургууль*

Аливаа толь тухайн цаг үеийнхээ соёлын өв, түүхийн гэрч болдог гэж үздэг. Монголчууд тайлбар толь зохиох эртний уламжлалтай бөгөөд янз бүрийн цаг үед зохиогдсон толиуд нь зорилго, толь бичигт туссан үгийн цаг хугацаа хамрах байдалтай холбоотойгоор багтаасан үгийн тоо хэмжээ, үгийн сангийн нэгжүүдийн хэрэглээний хүрээгээр ялгаатай байдаг.

Энэхүү илтгэлдээ Ц.Шагдарсүрэнгийн тодорхойлсноор “... монгол толь зүйн уламжлал, түрүүн гарсан монгол хэлний олон толь бичгийн ололт, улмаар боловсронгуй болгох зэрэг өргөн асуудлыг эрдэм шинжилгээний үүднээс нэгтгэн дүгнээд, монгол толь зүйн ерөнхий тогтолцоог орчин цагийн шинжлэх ухаан технологийн дэвшлийн өнөөгийн түвшинтэй уялдуулж боловсруулах асуудал...”-ын хүрээнд “Хорин нэгт тайлбар толь”, “Гучин зургаат тайлбар толь”, Б.Шагж “Эрэхүйеэ хялбар болгон зохиосон монгол үгийн тайлбар чандманийн эрх”, “Хорин наймт тайлбар толь” –уудад толгой үгийг тогтоож ирсэн уламжлал, арга зүйг судалсан судалгааны үр дүнгээ танилцуулах юм.

## **Монгол хэлний адууны тоног хэрэгслийг илтгэсэн зарим үг, хэллэгийн тухай**

Э.Алтаншагай  
*Өвөр Монголын Их Сургууль*

Тус өгүүлэлд монгол хэлний адууг барих, бэхлэх, уях сойх, тэжээх арчлах, тэрэг, чарганд хөллөхтэй холбогдох тоног хэрэгслийг илтгэсэн үг, хэллэгийг нийгэм хэл шинжлэлийн асуулгын болон тооцооллын аргаар судлав. Судалгаанд Сүхбаатар аймгийн Асгат, Баяндэлгэр, Мөнххаан сум; Хэнтий аймгийн Батширээт; Дундговь аймгийн Цагаан дэлгэр; Увс аймгийн Өлгий сумын малчдыг хамруулж, малын тоног хэрэгслийг илтгэсэн үг, хэллэгийн уламжлалт мэдлэг, өнөөгийн хэрэглээний байдлын тухай судалгаа хийлээ. Мөн бид зах зээлд худалдан борлуулж буй малын тоног хэрэгслийн байдлыг тодруулах зорилгоор “Нарантуул” олон улсын худалдааны төвд малын тоног хэрэгсэл худалдан борлуулагчдаас асуулга судалгаа авч, улмаар “нүүр ном”, “unegui.mn” зэрэг цахим хэрэглэгдэхүүн дэх малын тоног хэрэгсэл худалдан борлуулах зорилготой зар сурталчилгаанд буй адууны тоног хэрэгслийг илтгэсэн үг, хэллэгт ажиглалт хийв. Ийнхүү судлахад малчдын адууны тоног хэрэгслийг илтгэсэн үг хэллэгийн мэдлэг ба хэрэглээний байдал нь тухайн малчны нас, амьдарч буй бүс нутаг, мал малласан туршлага зэргээс шалтгаалан харилцан адилгүй байгаа нь илрэв. Түүнчлэн зах зээлд худалдан борлуулж байгаа адууны тоног хэрэгслийг хийж буй материалынх нь төрөл зүйлээс хамааран наймаачид олон янзаар нэрлэж заншсан байх бөгөөд нийгмийн хөгжил эрэлт хэрэгцээнд тулгуурласан шинэ тоног хэрэгсэл бий болж улмаар түүнийг даган үүссэн шинэ үг, хэллэг ч буй болжээ. Басхүү орчин цагийн техник технологийн хөгжил, цахим хэрэглээ, даяарчлалын нөлөөллийн улмаас адууны тоног хэрэгслийг илтгэсэн зарим уламжлалт үг, хэллэг бүдгэрэн балархайших үзэгдэл судалгааны үр дүнгээс ажиглагдав. Тус өгүүлэл нь БНХАУ-н Нийгмийн шинжлэх ухааны фондын «Монголчуудын хэлний амьдралын шинжилгээ» хэмээх томоохон төслийн (төслийн дугаар 17ZDA316) дэмжлэгтэйгээр хийгдэж байгаа “Монгол хэлний таван хошуу малын тоног хэрэгслийг илтгэсэн үг хэллэгийн нийгэм хэл шинжлэлийн судалгаа” судалгааны ажлын нэг хэсэг болно.

## **Монгол хэлний эсрэг утгатай үйл үгийн тухай**

Ж.Буяндэлгэр  
*Этүгэн Их Сургууль*

Эсрэг үг нь үгийн сангийн утга хоорондын холбоонд үндэслэдэг бөгөөд тэдгээрийн эсрэгцлийн үр дүн болдог. Энэхүү эсрэг тэсрэг байдал нь харьцангуй ойлголт бөгөөд байгаль, нийгэм, сэтгэхүйн бүх үзэгдэлд нэгэн адил байдаг тун өргөн ухагдахуун төдийгүй уг хэлээр харилцагч хүмүүсийн амьдралын туршлага, мэдлэг чадвар, ажил мэргэжил хийгээд нийгэм ахуйн янз бүрийн нөхцөл байдалтай уялдан юуг юутай хэрхэн эсрэгцүүлэх нь хүртэл өөр өөр байна.

Монгол хэлний эсрэг утгат үйл үгийг хэлний түвшинд хам үгсийн гадна харьцаанд орж эсрэг утгыг бий болгож байвал хэлний, зөвхөн хам үгийн доторх харьцаанд орж байж эсрэг утгыг илтгэж байвал хэлэхүйн эсрэг үг гэж ялгадаг бөгөөд үгийн сан- утгазүйн хувьд нэг буюу хэд хэдэн шинжээрээ эсрэгцсэн аль нэгэн харьцаанд хамаарах үгийн нэг аймгийн эсрэгцсэн утга бүхий хэлнээ хэвийн тогтсон үгсийг эсрэг үг гэж болох ба харин утга зүйн нэгэн оронд хамаарахгүй боловч хэрэглээний явцад эсрэг утга үүсгэх үгсийг хэлэхүйн эсрэг үг гэж болно.

## **Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрийн аялгыг туршилт авиазүйн аргаар судлах нь**

Г.Цэнд-Аюуш

*Москвагийн Улсын Хэл Шинжлэлийн Их Сургууль*

Энэхүү өгүүлэлд орчин цагийн монгол хэлний өгүүлбэрийн аялгыг судалсан судалгаануудыг тоймлосноос гадна 20-86 насны таван эрэгтэй, таван эмэгтэй оролцогчийн хүрээнд цуглуулсан 800 дуу бичлэгийг PRAAT программд боловсруулан анализ хийсэн туршилтын үндсэн дээр орчин цагийн монгол хэлний өгүүлбэрийн аялгыг нарийвчлан тодорхойлох гэж оролдсон судалгааны ажлын үр дүнг танилцуулсан болно.

